



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 19/619

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2023 оны 18 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын хэрэгцээ шаардлагад үндэслэн “Танхимын болон цахим сургалт”-ын нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж түвшин тогтоох ажлын дагуу сумдын Засаг даргын Тамгын газар, тосгодын Захирагчийн ажлын албаны ажилчдад зориулсан “Байгууллагын соёл, багаар ажиллах ур чадвар, манлайлах ур чадвар” сэдэвт сургалт, арга хэмжээнд зориулж 6,000,000 (зургаан сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Сургалт арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ